

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ
ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН
ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

Говьсүмбэр аймаг

2024

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 206 тоот

2024 оны 12 дугаар сар

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс
санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу,
хуваарилсан байна. 7

1.1 Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд улсын
төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн төлөвлөлтөд аймгийн
сонгуулийн хороо болон төрийн захиргааны байгууллагуудаас
санал аваагүй байна.7

1.2 Ээлжит сонгуулийн хороодод зардлын төсвийг
үндэслэлтэй хуваарилсан байна.7

Шатахууны зардлыг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулаагүй,
зарцуулалтад тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
9

2.1 Унааны зардалд зарцуулсан шатахууныг үр ашигтай,
арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.9

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.12

2.3 Засгийн газрын нөөц хөрөнгөөс орон нутгийн 2024 оны
ээлжит сонгуульд санхүүжилт хуваарилаагүй байна.13

2.4 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн
хорооны төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.13

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МТБ	Мэдээлэл технологийн байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СНЖ	Сонгогчийн нэрсийн жагсаалт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ АРГА ЗҮЙН ТАЛААРХ
МЭДЭГДЭЛ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу нийцлийн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороо, бусад холбогдох байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам
- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитад аймаг, сумдын Сонгуулийн хороо, аймгийн Цагдаагийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг MNS6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, дэд зорилт, асуудлын шинжилгээнд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн, аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг боловсруулан, дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

Төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө, орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитууд хугацааны хувьд давхардсан нь хүндрэл учруулж байсан.

Үндсэн мэдээлэл:

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолоор аймгийн сонгуулийн хороог байгуулсан. Аймгийн сонгуулийн хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор сумдын сонгуулийн хороог байгуулсан бөгөөд орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд 127 төрийн албан хаагч томилогдон ажилласан байна.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд 3 нам, 187 нэр дэвшигч оролцсон байна.

Аймгийн Сонгуулийн хорооны даргаар аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг, нягтлан бодогчоор аймгийн СХДАА-ны дарга Н.Алтанцэцэг нар томилогдсон байна.

Хүснэгт №1. Орон нутгийн -ын 2024 оны ээлжит сонгуулиар хуваарилсан зардлын төсөв

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Хуваарилагдсан төсөв
1	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс	15,964.0
2	Улсын бүртгэлийн хэлтэс	12,724.1
3	Аймгийн Сонгуулийн хороо	160,924.6
Нийт дүн		189,612.7

Хүснэгт товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв	7
Хүснэгт 2	Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв	8
Хүснэгт 3	Аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардлын төсөв	9
Хүснэгт 4	Аймгийн Улсын бүртгэлийн хуваарилсан зардлын төсөв	9
Хүснэгт 5	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Хүснэгт 6	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Хүснэгт 7	Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	12

БҮЛЭГ 1

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу, хуваарилсан байна.

1.1 Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн төлөвлөлтөд аймгийн сонгуулийн хороо болон төрийн захиргааны байгууллагуудаас санал аваагүй байна.

1.2 Ээлжит сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021.03.19-ний өдрийн А/17 тушаалаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1¹-г заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын хуваарилалтыг хийх зохицуулалттай байна.

СЕХ-ны тамгын газрын 2024 оны 3/777, 3/384, 3/852, 3/893, 3/909, 3/940 дугаартай албан бичгээр аймгийн сонгуулийн хорооны санхүүжилтийн хуваарийг тайлбарын хамт тус тус хүргүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт №01 Аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	2024.08.19	2024.09.05	2024.09.13	2024.09.23	2024.09.27	2024.10.05
1	Маягт, үнэмлэх хэвлэх зардал	325.0	325.0	325.0	325.0	325.0	325.0
2	Сонгуулийн байгууллагын ажилтны сургалтын зардал	3,660.0	3,660.0	3,660.0	3,660.0	3,660.0	3,660.0
3	МТБаг, даамлын сургалтын зардал	2,040.0	2,850.0	2,850.0	2,850.0	2,850.0	2,850.0
4	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал		2,050.0	2,050.0	2,050.0	2,050.0	2,050.0
5	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шуудан холбооны зардал		2,450.0	2,450.0	2,450.0	2,450.0	2,450.0
6	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны унааны зардал		8,970.0	8,970.0	8,970.0	8,970.0	8,970.0
7	Санал авах байр бэлтгэх зардал		2,800.0	2,800.0	2,800.0	2,800.0	2,800.0
8	Сурталчилгааны зардал			5,000.0	5,000.0	5,000.0	5,000.0
9	Мэдээлэл технологийн багийн зардал			780.0	780.0	780.0	780.0
10	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал			11,420.0	11,420.0	11,420.0	11,420.0
11	Томилолтын зардал			5,048.0	5,048.0	5,048.0	5,048.0
12	Сүлжээний судалгаа хийх зардал				640.0	640.0	640.0
13	Саналын хуудас устгах зардал				1,352.8	1,352.8	1,352.8
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал				280.0	280.0	280.0
15	Санал авах байрны түлшний зардал					300.0	300.0

¹ Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна.

16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	1,400.0	1,400.0			
17	Шуурхай багийн зардал Сонгуулийн хорооны	1,740.0	1,740.0			
18	гишүүдийн урамшуулал хоолны зардал					91,873.6
19	МТБаг, даамлын урамшуулал, хоолны зардал					16,195.2
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх					950.0
21	Болзошгүй зардал					840.0
	НИЙТ	6,025.0	23,105.0	45,353.0	47,625.8	160,924.6

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын албан бичиг,

Аймгийн сонгуулийн хороонд орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотой санхүүжилтийн хуваарийг 6 удаа хүргүүлсэн байна.

Сумдын сонгуулийн хорооны батлагдсан төсвийг зардлын нэр төрөл бүрээр харуулбал:

Хүснэгт №02 Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв / мянган төгрөгөөр /

№	Зардлын нэр	Төсөв	Сумдад хуваарилсан төсөв		
			Сүмбэр сумын Сонгуулийн хороо	Шивээговь сумын Сонгуулийн хороо	Баянтал сумын Сонгуулийн хороо
1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал	1,650.0	870.0	390.0	390.0
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шуудан холбооны зардал	1,950.0	1,050.0	450.0	450.0
3	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны унааны зардал	6,520.0	3,860.0	1,330.0	1,330.0
4	Санал авах байр бэлтгэх зардал	2,800.0	1,680.0	560.0	560.0
5	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	280.0	280.0	-	-
6	Санал авах байрны түлшний зардал	300.0	300.0	-	-
7	Сурталчилгааны материал тараах унааны зардал	1,400.0	840.0	280.0	280.0
8	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал хоолны зардал	83,104.0	45,438.4	20,910.4	16,755.2
9	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	12,264.0	7,358.4	2,452.8	2,452.8
10	Болзошгүй зардал	840.0	560.0	140.0	140.0
	НИЙТ	111,108.0	62,236.8	26,513.2	22,358.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны даргын захирамж 2024.10.08 №22,

Аймгийн Сонгуулийн хороо хуваарилагдаж ирсэн төсвөөс Сүмбэр суманд 39% буюу 62,236.8 мянга, Шивээговь суманд 16.5% буюу 26,513.2 мянга, Баянтал суманд 14% буюу 22,358.0 мянга, нийт 69.5% буюу 111,108.0 мянган төгрөгийн төсвийг сумдын сонгуулийн хороонд хуваарилсан байна.

Орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой аймгийн Цагдаагийн хэлтэст 15,964.0 мянга, Улсын бүртгэлийн хэлтэст 12,724.1 мянган төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан хуваарилсан байна.

Төсвийн хуваарилалтыг зардлын нэр, төрлөөр задалж харуулбал:

Хүснэгт №03 Аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардлын төсөв / мянган төгрөгөөр

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Хоолны зардал	10,704.0
2	Шуудан холбооны зардал	4,260.0

3	Шатахууны зардал	1,000.00
	Нийт дүн	15,964.0

Эх сурвалж: ЦЕГ-ын 2024.10.02-ны өдрийн №16/3171 дугаар албан бичиг, хавсралтууд

Хүснэгтээс харахад: Цагдаагийн хэлтсийн нийт хуваарилагдсан төсвийн 67%-ийг хоолны зардал эзэлж байна.

Хүснэгт №04 Аймгийн Улсын бүртгэлийн хуваарилсан зардлын төсөв

№	Зардлын нэр	/мянган төгрөгөөр/ Батлагдсан төсөв
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардлын төсөв	5,197.5
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах төсөв	523.6
3	Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороодод хүргэх зардал	740.0
4	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардлын төсөв	1,580.0
5	Сургалтын бусад зардал	247.0
6	Сонгогчийг бүртгэх, техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн төсөв	1,136.0
7	Тээврийн зардал	3,200.0
8	Шуурхай багийн зардал	100.0
	Нийт дүн	12,724.1

Эх сурвалж: УБЕГ-ын 2024.08.26-ны өдрийн №4/136 дугаар тушаал

Хүснэгтээс харахад: УБХ-ийн нийт хуваарилагдсан төсвийн 41 хувийг мөнгөн урамшуулал, хоол унааны зардал эзэлж байна.

БҮЛЭГ 2

Шатахууны зардлыг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, зарцуулалтад тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

2.1 Унааны зардалд зарцуулсан шатахууныг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

Аймгийн Сонгуулийн хороонд Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс нийт 160,924.6 мянган төгрөг батлагдсаныг бүрэн зарцуулсан байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороо нь шатахууны зардлыг олгохдоо гүйцэтгэх ажлын удирдамж, маршрут зэргийг урьдчилан баталж, гүйцэтгэлийн байдалд хяналт хэрэгжүүлдэггүй төсвийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах бодлого баримтлаагүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул байна. Тухайлбал:

- Аймгийн сонгуулийн хорооны шатахуун зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс 660.9 мянган төгрөгийн шатахууны зардлыг автомашины бодит гүйлт, нормд үндэслэн тооцож олгоогүй.
- Сүмбэр сумын сонгуулийн хорооны сурталчилгааны материал тараах унааны зардалд 840.0 мянган төгрөг хуваарилагдсан боловч гүйцэтгэлээр 1,254.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, хуваарилсан төсвөөс 414.6 мянган төгрөгийг болзошгүй зардал болон санал авах байрны түлшний зардлаас зардлын зүйл анги хооронд шилжүүлэн зарцуулсан.

Энэ нь Сумын сонгуулийн хороо шаардлагатай зардлын зүйл анги хооронд зохицуулалт хийлгэх хүсэлтийг аймгийн Сонгуулийн хороондоо уламжлан шийдвэрлүүлээгүй, уялдаа холбоо сул, хяналтын тогтолцоо бүрдээгүй байгааг харуулж байна.

Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэхийг тулган баталгаажуулахад 560.5 мянган төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

Сумын сонгуулийн хороо:

- Сүмбэр сумын сонгуулийн хороо нь цахилгаан эрчим хүч тасраагүй байхад төвийн 2 хэсгийн хороонд цахилгаан эх үүсвэрт 168.0 мянган төгрөгийн шатахууныг зардлаар бүртгэсэн.
- Баянтал сумын сонгуулийн хэсгийн хороонд ажилласан албан хаагчид 249.9 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудсыг давхардуулан бичсэн
- Шивээговь сумын сонгуулийн хороо анхан шатны баримтгүй, жолоочийн тооцооны хуудсаар баталгаажаагүй 42.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Аймгийн сонгуулийн хороо:

- Автомашин шатахууны зарцуулалтын нормыг тууштай баримтлаагүй, үндэслэлгүйгээр нэмэгдүүлснээс 100.6 мянган төгрөгийн шатахууныг илүү тооцож олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1², Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4³, 13 дугаар зүйлийн 13.1⁴, 13.7⁵, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.2.3⁶, 20.2.4⁷, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт ТМ-4, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 4 дүгээр зүйлийн 4.1⁸ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд жолоочийн тооцооны хуудсыг давхардуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан Сүмбэр сумын сонгуулийн хорооны 168.0 мянга, Шивээговь сумын сонгуулийн хорооны 42.0 мянга, Баянтал сумын сонгуулийн хорооны 249.9 мянга, аймгийн Сонгуулийн хорооны 100.6 мянга, нийт 560.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Хүснэгт №05 Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Хувь
1	Хоолны зардал	10,704.0	10,704.0	0.0	-
2	Шуудан холбооны зардал	4,260.0	4,260.0	0.0	-
3	Шатахууны зардал	1,000.00	1,000.00	0.0	-
	Нийт дүн	15,964.0	15,964.0	0.0	-

Эх сурвалж: Аудиторын тооцоолол ажлын баримт №01

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс аймгийн Цагдаагийн хэлтэст хуваарилсан хамгаалалтын зардалд 15,964.2 мянган төгрөг батлагдсаныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

² төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

³ үнэн зөв байх

⁴ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

⁵ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁶ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах

⁷ нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах

⁸ Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө.

Аймгийн Цагдаагийн хэлтэс нь жолоочийн тооцооны хуудсанд 565.4 мянган төгрөгийн шатахууны тооцоог спидометрийн заалт бичихгүйгээр зарцуулсан байх тул аудитын явцад дээрх зөрчлийг арилгуулсан. Энэ нь шатахуун зарцуулалтад тавих хяналт сул байгааг харуулж байна.

Аудитаар аймгийн Цагдаагийн хэлтэс нь анхан шатны баримтгүй, жолоочийн тооцооны хуудсаар баталгаажаагүй 39.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4¹⁰, 13 дугаар зүйлийн 13.1¹¹, 13.7¹², 14 дүгээр зүйлийн 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.2.3¹³, 20.2.4¹⁴, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт ТМ-4, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 4 дүгээр зүйлийн 4.1¹⁵ дэх заалтуудыг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Иймд аймгийн Цагдаагийн хэлтсийн 39.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Хүснэгт №06 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардлын төсөв	5,197.5	5,197.5	-
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах төсөв	523.6	523.6	-
3	Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороодод хүргэх зардал	740.0	740.0	-
4	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардлын төсөв	1,580.0	1,580.0	-
5	Сургалтын бусад зардал	247.0	247.0	-
6	Сонгогчийг бүртгэх, техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн төсөв	1,136.0	1,136.0	-
7	Тээврийн зардал	3,200.0	3,200.0	-
8	Шуурхай багийн зардал	100.0	100.0	-
Нийт		12,724.1	12,724.1	-

Эх сурвалж: Аудиторын тооцоолол ажлын баримт, УБХ-ийн тайлан, анхан шатны баримт

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлаас УБХ-т 12,724.1 мянган төгрөг хуваарилагдаж 12,724.1 мянган төгрөгийг 100 хувь зарцуулжээ.

Аудитаар УБХ-т хуваарилсан төсвийн зарцуулалтыг анхан шатны баримтуудтай тулган баталгаажуулахад 79.3 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг илүү тооцож олгосон зөрчил илэрсэн байна.

⁹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹⁰ үнэн зөв байх

¹¹ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

¹² Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

¹³ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах

¹⁴ нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах

¹⁵ Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁶, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4¹⁷, 13 дугаар зүйлийн 13.1¹⁸, 13.7¹⁹, 14 дүгээр зүйлийн 14.3.1²⁰, 20 дугаар зүйлийн 20.2.3²¹, 20.2.4²², 20.2.5²³, 20.2.7²⁴, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт ТМ-4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороо сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв тайлагнасан байна. Сонгууль зохион байгуулахтай холбогдон батлагдсан төсвөөр хөрөнгө бэлтгээгүй байна.

Хүснэгт №07 Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл
1	Маягт, үнэмлэх хэвлэх зардал	325.0	325.0
2	Сонгуулийн байгууллагын ажилтны сургалтын зардал	3,660.0	3,660.0
3	МТБаг, даамлын сургалтын зардал	2,850.0	2,850.0
4	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал	2,050.0	2,050.0
5	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шуудан холбооны зардал	2,450.0	2,450.0
6	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны унааны зардал	8,970.0	8,970.0
7	Санал авах байр бэлтгэх зардал	2,800.0	2,800.0
8	Сурталчилгааны зардал	5,000.0	5,000.0
9	Мэдээлэл технологийн багийн зардал	780.0	780.0
10	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	11,420.0	11,420.0
11	Томилолтын зардал	5,048.0	5,048.0
12	Сүлжээний судалгаа хийх зардал	640.0	640.0
13	Саналын хуудас устгах зардал	1,352.8	1,352.8
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	280.0	280.0
15	Санал авах байрны түлшний зардал	300.0	300.0
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	1,400.0	1,400.0
17	Шуурхай багийн зардал	1,740.0	1,740.0
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал хоолны зардал	91,873.6	91,873.6
19	МТБаг, даамлын урамшуулал, хоолны зардал	16,195.2	16,195.2
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх	950.0	950.0
21	Болзошгүй зардал	840.0	840.0
НИЙТ		160,924.6	160,924.6

Эх сурвалж: Аудиторын тооцоолол ажлын баримт, АСХ-ны тайлан

¹⁶ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹⁷ үнэн зөв байх

¹⁸ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

¹⁹ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

²⁰ анхан шатны баримт бүрдүүлэх

²¹ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах

²² нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах

²³ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

²⁴ аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах

Хүснэгтээс харахад: Батлагдсан төсвийг 100 хувь зарцуулж, буцаан төвлөрүүлсэн үлдэгдэл байхгүй байна.

Шивээговь, Баянтал сумын сумын сонгуулийн хороо 286.4 мянган төгрөгийн сонгуулийн хорооны гишүүдийн урамшууллын зардлыг хэмнэж, аймгийн Сонгуулийн хороонд буцаан төвлөрүүлсэн бөгөөд Баянтал суманд санал тэнцсэнтэй холбоотой нэмэлт санал хураалт зохион байгуулах зардалд 286.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.3 Засгийн газрын нөөц хөрөнгөөс орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд санхүүжилт хуваарилаагүй байна.

2.4 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 3 дугаар зүйлийн 3.10²⁵ заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй боловч хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар нийт 679.6 мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

²⁵ Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу, хуваарилсан байна.

- Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн төлөвлөлтөд аймгийн сонгуулийн хороо болон төрийн захиргааны байгууллагуудаас санал аваагүй байна.
- Ээлжит сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Шатахууны зардлыг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, зарцуулалтад тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

- Унааны зардалд зарцуулсан шатахууныг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.
- Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.
- Засгийн газрын нөөц хөрөнгөөс орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд санхүүжилт хуваарилаагүй байна.
- Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.